



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/233

Ховд

Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын Хөшөөт хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 2.7-д Сувилахуйн төв байгуулахаар тусгагдсан 90,000,000 төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал (П.Гэрэлсүрэн)-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээр хянуулан баталгаажуулсны үндсэн дээр, худалдан авах ажиллагааг 04 дүгээр сарын 20-ны дотор холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлттэй, зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулж, ашиглалтад хүлээн авах арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг 05 дугаар сарын 10-ны дотор тайлагнахыг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал (П.Гэрэлсүрэн)-д даалгасугай.


3. Эрх шилжүүлж буй хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх)-д хариуцуулсугай.

4. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, нийлүүлсэн тоног төхөөрөмжийг харьяа байгууллагын өмчийн бүртгэлд тусгуулж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Ш.Нохойжав), холбогдох бичиг баримтын

8400 01 1162

бүрдлийг хянаж, санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Даваадорж) нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.

ДАРГА  Б.ДУГЭРЖАВ

